



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот



Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ачтан” эмнэлгээс Монгол Улсын Ерөнхий сайд, Ч.Сайханбилэг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбат болон Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгчийн нэр дээр ирүүлсэн гомдолд дурдсан эмнэлгүүдийн үйл ажиллагаанд ялгавартай хандсан, гэрээний биелэлтийг нь албан ёсоор дүгнээгүй зэрэг нь үнэн байх тул нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудад ялгаваргүй тэгш байдлыг хангах үүднээс Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээг шинэчлэн батлах тухай сайдын 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 75 дугаар тушаалын хавсралтад нэмэлт оруулсугай.

2. Нийслэлийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээг нэмэлт төлбөргүйгээр үзүүлэхийг “Ачтан-Элит” эмнэлэг /Ц.Мухар/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д даалгасугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080662

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 18 өдрийн
11/16 дугаар тушаалын хавсралт



Тусламж, үйлчилгээний төрөл	Дүүргийн нэр								
	Баянгол	Баянзүрх	Багануур	Багахангай	Налайх	Сонгино хайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй
Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	“Номун” эмнэлэг	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Багануур эрүүл мэндийн төв	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Налайх эрүүл мэндийн төв	“Мишээл” эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	“Мишээл” эмнэлэг	“Номун” эмнэлэг
						“Ачтан” эмнэлэг		“Ачтан” эмнэлэг	
Лавлагаа тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	Улсын гуравдуг аар төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын гуравдугаар төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг